

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУГАЦААТ ҮЗЛЭГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэг. Зорилго:

Эрүүл мэндийн хугацаат үзлэг нь ажилтны эрүүл мэндийг тандах, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт үед нь илрүүлж, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилготой.

Хоёр. Эрх зүйн үндэслэл:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14-р зүйл, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 340 дүгээр тушаалаар баталсан “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам”.

Гурав. Эрүүл мэндийн хугацаат үзлэгт орох ажилтны тоо, хөдөлмөрийн нөхцөл:

- “МИАТ” ТӨХК-ийн үндсэн 1078 ажилтан, эрэгтэй -619, эмэгтэй-459
- Хөдөлмөрийн нөхцөлийн ангиллаар: хэвийн- 591, хүнд, хортой- 487

Дөрөв. Үзлэгийн төрөл, хүрээ:

Багцын №	Эмчийн үзлэг	Багажийн шинжилгээ	Лабораторын шинжилгээ
Багц 1	<ul style="list-style-type: none"> • Дотор • Зүрх судас • Уушиг • Нүд • Чих хамар хоолой • Дотоод шүүрэл • Мэдрэл • Бөөр • Мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын эмч 	<ul style="list-style-type: none"> • Зүрхний цахилгаан бичлэг • Зүрхний өнгөт эхо • Хэвлийн хэт авиа • Сонсгол шалгах • Цээжний рентген • Нүдний дуран 	<ul style="list-style-type: none"> • Цусны дэлгэрэнгүй шинжилгээ • Шээсний ерөнхий шинжилгээ • Биохими • АЛАТ, АСАТ, Билирубин • Креатинин • Триглицерид, Холестрин, HDL, LDL • Элэгний В,С /тест/ • Бамбайн даавар • TSH, T3, T4 • Эрдсийн шинжилгээ
Багц 2	<ul style="list-style-type: none"> • Дотор • Зүрх судас • Уушиг • Нүд • Чих хамар хоолой • Дотоод шүүрэл • Мэдрэл 	<ul style="list-style-type: none"> • Улаан хоолой, Ходоодны дуран эсвэл бүдүүн гэдэсний дуран аль нэг нь ажилтны сонголтоор /Унтуулгагүй, хэрвээ унтуулгатай орвол 	<ul style="list-style-type: none"> • Цусны дэлгэрэнгүй шинжилгээ • Шээсний ерөнхий шинжилгээ • Биохими • АЛАТ, АСАТ, Билирубин • Креатинин

	<ul style="list-style-type: none"> • Бөөр • Мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын эмч 	зөрүү төлбөрийг ажилтан өөрөө төлнө/ <ul style="list-style-type: none"> • Хэвлийн хэт авиа • Фиброскан • Цээжний рентген • Нүдний дуран 	<ul style="list-style-type: none"> • Триглицерид, Холестрин, HDL, LDL • Элэгний В,С /тест/ • Бамбайн даавар • TSH, Т3, Т4 • Хелико бактери • Эрдсийн шинжилгээ
Багц 3	Хавдрын эмчийн үзлэг, зөвлөгөө	Хавдрын маркерууд <ul style="list-style-type: none"> • CA-19-9 Нойр булчирхайн хавдрын маркер • CA72-4 Ходоодны хавдрын маркер • CEA Бүдүүн шулуун гэдэсний хавдрын маркер • AFP /Alpha Feta/ Элэгний хавдрын маркер • Cyfra 21-1 Уушигны хавдрын маркер • PSY Түрүү булчирхайн хавдрын маркер • CA 125 Өндгөвчний хавдрын маркер • CA 15-3 Хөхний хавдрын маркер 	

Тав. Эрүүл мэндийн үзлэг хийх эмнэлэг болон эмч, эмнэлгийн ажилтны багт тавигдах шаардлага:

5.1. Эмнэлэгт тавигдах шаардлага:

- 2, 3-аар шатлалын клиник эмнэлэг байна.
- 7-оос доошгүй чиглэлээр лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээг амбулатори болон хэвтэн эмчлэх хэлбэрээр үзүүлдэг, магадлан итгэмжлэгдсэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх;
- Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулж байсан туршлагатай байх.

5.2. Эмч, эмнэлгийн ажилтны багт тавигдах шаардлага:

Эмч, эмнэлгийн ажилтны баг бүрэлдэхүүн нь тухайн байгууллагадаа 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх ба Ерөнхий эмч, ахлах зэргийн эмч, нарийн мэргэжлийн эмчийн 50 хувь нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байна.

№	Үзлэг хийх чиглэл	Ажиллах хүний тоо	Туршлага /ажилласан жилээр/	Үндсэн болон гэрээт ажилтан эсэх
1	Ерөнхий эмч	1	10-аас доошгүй жил ажилласан	Үндсэн
2	Ахлах зэргийн эмч	1	10-аас доошгүй жил ажилласан	Үндсэн

3	Нарийн мэргэжлийн эмч	6	5-аас доошгүй жил ажилласан	50 хувь нь үндсэн, 50 хувь нь гэрээт байж болно.
4	Лаборант	1	5-аас доошгүй жил ажилласан	Үндсэн
5	Мэргэжлээс шалтгаалах судлалын эмч өвчин	1	5-аас доошгүй жил ажилласан	Гэрээт байж болно.

Санал болгож буй эмчийн дипломын хуулбар, эмчлэх эрхийн лицензийн хуулбарыг хавсаргана.

Жич: Үзлэг шинжилгээг тухайн мэргэжлээр, эсхүл тухайн багаж тоног төхөөрөмж дээр ажилласан туршлага дутмаг, дадлагажигч, резидент эмч, эмнэлгийн ажилтнаар хийлгэхгүй.

Зургаа. Эмнэлгийн тоног төхөөрөмж:

Олон улсын дэвшилтэт орчин үеийн технологи бүхий аппарат, тоног төхөөрөмж бүхий лаборатори, өөрийн байртай байх шаардлагатай ба дараах үйлчилгээг үзүүлэх боломжтой тоног төхөөрөмжтэй байна:

Жич:Чанарын шаардлага хангасан гэрээт лаборатори байж болно.

№	Тоног төхөөрөмжийн жагсаалт	Тоо ширхэг
1.	ЭХО аппарат	2
2.	Зүрхний эхо, зүрхний цахилгаан бичлэг	1
3.	Дижитал рентген	1
4.	Нүдний дуран	1
5.	Чих хамар хоолойн үзлэгийн дуран	1
6.	Хеликобактер илрүүлэгч	1
7.	Соронзон үелзүүрт томографи	1
8.	Компьютер томографи	1
9.	Уушгины багтаамж шалгах аппарат	1
10.	Фиброскан	1

Тайлбар: Дээрх тоног төхөөрөмжүүдийн танилцуулга, бодит зургийг хавсаргаж ирүүлнэ.

Долоо. Бусад тавигдах нөхцөл шаардлага:

- Ажил олгогчийн эрүүл мэндийн хугацаат үзлэгийн багцын үзлэгт хамрагдахад тухайн ажилтны эрүүл мэндийн даатгалаас нэмэлт төлбөр авахгүй байх;
- Үзлэгт хамрагдсан ажилтнуудаас онош тодруулах нэмэлт шинжилгээ, оношилгоо хийх, мөн хэвтэн эмчлүүлэх, эмийн болон мэс заслын тусламж үйлчилгээг шаардлагатай ажилтнуудад эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтөөр үзүүлэх;
- Нэмэлтээр эрүүл мэндийн даатгалд хамруулан үзүүлэх боломжтой үйлчилгээний жагсаалт ирүүлэх

- Ажилтанд мэргэжлээс шалтгаалсан өвчний онош тогтоох, урьдчилсан оношийг баталгаажуулах, мэргэжлийн тохироо тодорхойлох үзлэг шинжилгээ хийх;
- Ажилтны овог нэр, нас, лабораторийн шинжилгээний хариуг үнэн зөв гаргаж, гарсан санал гомдлыг шийдвэрлэх боломжтой байх;
- Эрүүл мэндийн үзлэгийг хэт ачаалал үүсгэхгүйгээр захиалагчаас батлагдсан хуваарийн дагуу хугацаанд нь чанартай сайн гүйцэтгэж, ажилтан тус бүрээр Ерөнхий эмчийн дүгнэлт гаргаж өгөх;
- Урьдчилан сэргийлэх үзлэгийг батлагдсан хуваарийн дагуу чанартай хийх, үзлэг хийх өдөр ажилтнуудыг халдвар хамгааллын дэглэм баримтлан цөөн тоогоор, нэгжийн зохион байгуулалттайгаар үзлэгт хамруулах;
- Өөр байгууллагын болон бусад гадны үйлчлүүлэгчтэй холихгүй байх ажлын хуваарилалт зохицуулалтыг хийсэн байх;
- Эрүүл мэндийн үзлэгт тодорхой шалтгааны улмаас хамрагдаж чадаагүй ажилтнуудыг дараа нь нөхөн үзлэгт хамруулах боломжтой байх; /албан мэдэгдэл авах/
- Үзлэг хийх өрөө кабинетыг дугаарлах, ажилтан үзүүлэх маршрут гаргах, үзлэгийн тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, бэлэн байдлыг хангаж ажиллах, эмчийн танилцуулгыг байршуулсан байх;
- Компанийн Агаарын хөлгийн засвар үйлчилгээний газар ажиллаж байгаа инженер техникийн болон компанийн төв байрны ажилтнуудад шинжилгээний сорьцыг /цус, шээс/ тухайн эмнэлгийн лаборатори хариуцсан мэргэжилтэн нь ажлын байранд өөрсдийн унаагаар ирж сорьц, шинжилгээний дээжийг авах ажлыг зохион байгуулах. /албан мэдэгдэл авах /

Найм. Үзлэгийн үр дүнг гаргах, тайлагнах:

- Эрүүл мэндийн үзлэг хийж дууссаны дараа ажилтнуудын лаборатори шинжилгээ, багажийн шинжилгээ, эмч нарын үзлэг, ерөнхий эмчийн дүгнэлт тус бүрийг нэгтгэж PDF файл болон хэвлэмэл хэлбэрээр захиалагч байгууллагын эмчид 30 хоногийн дотор хүргүүлэх.
- Үзлэгийн дүнг нэгж тус бүрээр гаргах буюу нэгтгэсэн байдлаар эрүүл мэндийн дүгнэлт гаргаж өгөх, цаашид анхаарах заавар, зөвлөмж өгч, эрүүл мэндийн хувьд анхаарах ажилтнуудын судалгааг өгнө.
- Үзлэгийн тайланг Эрүүл мэндийн сайдын 2014 оны 340-р тушаалын 4 хавсралтын дагуу ирүүлнэ. Үзлэгийн тайланд хавсаргах бичиг баримтыг гүйцэт ирүүлэх / Эрүүл мэндийн сайдын 2014 оны 340-р тушаалд заасан жагсаалтын дагуу хавсаргах /